



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР
НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

2022 оны 04
дүгээр сар

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021
ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2022 он

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. А.Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй байна.....	7
А.1 Замын сангийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.....	7
А.1.1. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ аймгийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж төлөвлөгдсөн байна.....	7
А.1.2 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүд нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.....	8
А.1.3 Төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй байна	8
А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй байна.	9
А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна	9
А.2.2 Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 88.2 хувь нь хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.....	9
А.2.3 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна	10
БҮЛЭГ 2. Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.....	10
Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна.....	10
Б.1.1. Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нарт эрх шилжүүлээгүй байна	10
Б.1.2. Төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна	10
Б.1.3. Шууд худалдан авалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажиллаагүй байна	11
Б.1.4 Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн худалдан авалтын тайланг гаргаагүй байна.....	11
Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан байна.....	12
Б.2.1. Тайлант онд шинээр хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй байна.....	12
Б.2.2. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	13
Б.2.3. Зам засварын ажлын төсөвт зохиогчийн хяналтын зардал тусгаадаагүйгээс хяналт хэрэгжээгүй байна	13
Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна	13
Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.....	14
Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.....	14
Б.3.2. Зам засварын ажлууд нь урсгал засварын шинжтэй ажлууд тул данс бүртгэлд тусгах шаардлагагүй байна.....	15
Б.4 Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийгдээгүй байна.	15
ДҮГНЭЛТ:.....	16
ЗӨВЛӨМЖ:.....	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	18

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ийн нэгдсэн судалгаа-гэрээ хийсэн огноо, ТАХ ашиглалтанд орсон огноо, дугаар	12
Хүснэгт 2	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ийн нэгдсэн судалгаа-санхүүжилт, гүйцэтгэл	14

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжэний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэхээр баталсан 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон бусад байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан Нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор У.Ербол нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

БҮЛЭГ 1. А.Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй байна

А.1 Замын сангийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна

А.1.1. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ аймгийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж төлөвлөгдсөн байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит II хуралдааны “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Орон нутгийн хөрөнгө оруулалтад хөрөнгө батлаагүй, харин Замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөв баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит V хуралдааны “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 41 дүгээр тогтоолоор Замын сангийн төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.

Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 2021 онд 17 төсөл арга хэмжээг шинээр, урьд оноос шилжиж ирсэн 2 төсөл арга хэмжээг үргэлжүүлэн, нийт 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөр, Баян-Өлгий аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн эсэхийг шалгаж үзэхэд:

- Алтай, Баяннуур, Булган, Дэлүүн, Улаанхус, Сагсай, Цэнгэл, Өлгий сумдад хийгдсэн зам засварын ажлууд, Сагсай, Булган, Дэлүүн, Цэнгэл сумдад хийгдсэн гүүр засварлах ажлууд Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, Баян-Өлгий аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.6.7-д “зарим сумдад шаардлагатай гүүр барих, зам засварлах ажлыг хэрэгжүүлнэ” гэж тусгагджээ.

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.1-д “... нийслэл, орон нутгийн авто замын сан нь Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ”, 2.2-т “Авто замын сангийн тухайн жилийн төсвийг Төсвийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдсон журмын дагуу боловсруулна” гэж заасан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 16 дугаар тогтоолоор Замын сангийн хөрөнгийг батлахдаа Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан эх үүсвэрээс бүрдүүлэх тооцоо хийгдээгүй байна.Тухайлбал:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 2020 онд аймгийн төсөвт нийтдээ 400.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд Замын сангийн 2021 оны төсвийг төлөвлөхдөө 2020 оны гүйцэтгэлд үндэслээгүй байна.

Мөн орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу ногдуулсан торгуулийн орлогыг, Замын санд орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгө, орон нутгийн автозам, зогсоол ашигласны төлбөр, автозамын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөрөөс орох орлогыг тооцож, замын сангийн төсвийг төлөвлөөгүй байна.

А.1.2 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүд нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 16, 2021 оны 41 дүгээр тогтоолоор Замын сангийн төсвийг төсөл арга хэмжээ тус бүрээр батлаагүй, нийт дүнгээр баталсан байна.

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.1-д “Авто замын сангийн хөрөнгийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус зориулалтын дагуу зарцуулна”, 3.3-д “гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, зам байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас автозамын хөдөлгөөний хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Сумын засаг дарга нараас гэнэтийн хүчин зүйлсийн улмаас авто зам, зам байгууламжид гарсан эвдрэл, гэмтлийг засвар хийлгэх талаар 2021 онд аймгийн Засаг даргад нийт 17 хүсэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс дээрх хүсэлтүүдийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн зайлшгүй засварлах шаардлагатай гэж үзсэн авто зам, замын байгууламжийг Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулан батлуулсан байна.

Зам засварлах шилжих 2 төсөл арга хэмжээ, зам засварлах шинэ 13 арга хэмжээ, гүүр засварлах 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөл арга хэмжээ тус бүрээр аймгийн Засаг даргын захирамж гаргасан байна.

Үүнээс үзэхэд тухайн орон нутгийн хэрэгцээнд шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн гэж үзэх үндэстэй байна.

А.1.3 Төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй байна

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Сумын засаг дарга нараас ирүүлсэн хүсэлтийн дагуу Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн, тухай бүр шийдэж ирсэн бөгөөд төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй байна.

А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй байна.

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит II хуралдааны “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор замын сангийн төсвийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тус бүрээр батлаагүй нийт дүнгээр баталсан байна.

Энэ нь: Сангийн Сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-т “...захиалагч худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна”, 2.2-т “захиалагч тухайн жилд худалдан авах бараа, үйлчилгээний төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн, төсөл арга хэмжээ нэг бүрээр энэхүү журмын Маягт-1-ийн дагуу боловсруулж ... тодорхой тусгасан байна”,

Төсвийн тухай хууль 29 дүгээр зүйлийн 29.3.3-т “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах”, 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтыг Төсвийн тухай хууль, холбогдох журмыг мөрдөж төсөл арга хэмжээ тус бүрээр батлуулж ажиллахыг зөвлөмж болголоо.

А.2.2 Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 88.2 хувь нь хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна

Замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 256.1 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулснаас 15 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжсэн байна.

Үүнд: Улаанхус сумын 1 дүгээр багийн /Хавтгайн/ замын засвар, Улаанхус сумын 4 дүгээр багийн /Улиастайн/ замын засвар, Улаанхус сумын 9 дүгээр баг, Улаан эрэгт үерийн далан босгох, Улаанхус сумын 7 дугаар баг, Билүүд үерийн далан босгох, Сагсай сумын Хар нуурын хөвөөний замын засвар, Сагсай сумын Даянгийн гүүрийн засвар, Баяннуур сум 1 км замын засвар, Цэнгэл сумын Ховд гол хавцлын замын засвар, Өлгий сумын хатуу хучилттай замын нөхөөс, Булган сумын Булган голын модон гүүрийн засвар, Цэнгэл сумын Хоромдогийн модон гүүрийн засвар, Сагсай сумын 2 дугаар багийн замын засвар, Дэлүүн сумын Буянт голын тумба гармын модон гүүрийн засвар, Алтай сумын 1 дүгээр багийн төвөөс Хар үзүүр хоорондын замын засвар, Буянт сумын доод сайгийн замын засвар зэрэг ажлууд хугацаанд хэрэгжсэн байна.

Цэнгэл сумын Арал толгой застав, Давааны хаяа уулын замын эхлэлээс Цагаан голын рашаан хүртэлх 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй замын засвар, Арал толгой

застав Цагаан голын рашаан замын эхлэлээс Даваа хүртэлх замын засварын ажлын 2 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна.

А.2.3 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна

Аймгийн Замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дотор хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

БҮЛЭГ 2. Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна

Б.1.1. Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нарт эрх шилжүүлээгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6-т “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно” гэж заажээ.

Аймгийн Засаг даргаас 2021 онд сумын Засаг дарга нарт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.

Б.1.2. Төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна

Замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл, арга хэмжээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй ажил учраас шууд гэрээгээр, 2 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Шууд гэрээ байгуулсан 17 төсөл, арга хэмжээний 15 нь гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж, 2 төсөл, арга хэмжээ тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй байна.

Алтай сумын 1 дүгээр багийн 25.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам засварын ажил, Буянт сумын 23.1 сая төгрөгийн өртөгтэй зам засварын ажлыг харьцуулалтын аргаар тендер зарлаж, худалдан авах ажиллагааг тайлант онд бүрэн хэрэгжих байдлаар зохион байгуулсан байна.

Үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д заасан шаардлагыг хангахуйц худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн АЗ сертификаттай, худалдан авах ажиллагааны салбарын мэргэжилтнүүд, аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын төлөөлөл, иргэний төлөөллийг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж ажиллуулсан байна.

Үнэлгээний хороо нь тендерийн бичиг баримтыг зохих журмын дагуу боловсруулж, тендер шалгаруулалтыг явуулсан ба тендертэй холбоотой ямар нэгэн маргаан, зөрчил дутагдал гараагүй байна.

Б.1.3. Шууд худалдан авалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажиллаагүй байна

Тухайн онд Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зам засварын 17 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөж, тендер шалгаруулалтын төлөвлөлтийг явцыг “tender.gov.mn” сайтад ил тод мэдээлж, гүйцэтгэгч компаниудыг нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан бөгөөд шууд гэрээгээр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн 15 төсөл, арга хэмжээг олон нийтэд мэдээлээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлахдаа жагсаалтыг батлаагүй тул аймгийн Орон нутгийн өмчийн газраас tender.gov.mn сайтад мэдээлэх боломжгүй болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 21 дүгээр зүйлийн 21.2, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1.3, 3.1, 3.2 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Аудитын дүнгээр хууль тогтоомж, журмуудыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

Б.1.4 Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн худалдан авалтын тайланг гаргаагүй байна

Алтай сумын 1 дүгээр багийн төвөөс Хар үзүүр хоорондын замын 52.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил, Буянт сумын доод сайгийн замын 23.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулсан боловч Аймгийн Орон нутгийн өмчийн газраас гаргасан худалдан авалтын тайланд оруулаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авалтын тайланг Сангийн сайдын 2021 оны 102 тоот тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу гаргаж тайлагнаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан байна**Б.2.1. Тайлант онд шинээр хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй байна**

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл, арга хэмжээний 15 төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах комисс”-т хүлээлгэн өгсөн байна.

Хүснэгт 01

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний				Хэрэгжиж дууссан		Ажлын гүйцэтгэл
		Байгуулсан		Ажил гүйцэтгэх хугацаа		Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын		
		Огноо	Үнийн дүн	Эхлэх огноо	Дуусах огноо	Актын дугаар	Актын огноо	
A	1	2	3	4	5	6	7	
1	Ногооннуур Ямаат хөхсайрын замын засвар	2020.7.20	8.4	2020.7.2	2020.10.01	№57/20	2020.12.23	100%
2	Улаанхус 1-р баг Хавтгайн / замын засвар	2021.5.14	9.8	2021.5.17	2021.7.20	№13	2021.6.14	100%
3	Улаанхус,4-р багийн / Улиастайн / замын засвар	2021.5.14	9.8	2021.5.20	2021.7.26	№13	2021.6.14	100%
4	Улаанхус 9-р баг, Улаан эрэгт үерийн далан босгох ажил	2021.4.09	9.7	2021.4.13	2021.4.25	№01	2021.4.20	100%
5	Улаанхус , 7-р баг, Билүүд үерийн далан босгох	2021.4.13	9.9	2021.4.17	2021.4.25	№01	2021.4.20	100%
6	Сагсай, Хар нуурын хөвөөний замын засвар	2021.6.30	9.8	2021.7.01	2021.7.22	№20	2021.8.04	100%
7	Ногооннуур, Бөхмөрөн чиглэлийн Ямаат баг, Хөхсайрын замын засвар	2019.12.24	9.7	2019.12.25	2020.4.30	№56/20	2020.12.23	100%
8	Цэнгэл, Арал толгой застав, давааны хаяа уулын замын эхлэлээс цагаан голын рашаан хүртэлх зам	2021.7.26	20.0	2021.7.27	2021.9.10			0
9	Цэнгэл Арал толгой застав Цагаан голын рашаан замын эхлэлээс Даваа хүртэлх зам	2021.7.26	20.0	2021.7.27	2021.9.10			0
10	Сагсай Даянгийн /хув үе/ гүүрийн засвар	2021.8.12	16.0	2021.8.13	2021.9.13	№22	2021.8.25	100%
11	Баяннуур 1км замын засвар	2021.09.23	15.0	2021.09.25	2021.10.25	№43	2021.10.20	100%
12	Цэнгэл, Ховд гол хавцлын замын засвар	2021.07.26	20.0	2021.07.27	2021.08.25	№27	2021.09.16	100%
13	Өлгий сумын хатуу хучилттай замын нөхөөсний ажил	2021.08.19	18.3	2021.08.20	2021.10.01	№56	2021.11.10	100%
14	Булган, Булган голын модон гүүрийн засвар	2021.07.05	8.0	2021.07.05	2021.08.05	№02	2021.10.04	100%
15	Цэнгэл, Хоромдогийн модон гүүрийн засвар	2021.08.02	20.0	2021.08.09	2021.11.15	№57	2021.11.12	100%
16	Сагсай, 2-р багийн замын засвар	2021.11.24	6.0	2021.11.24	2021.12.06	№76/21	2021.12.26	100%
17	Дэлүүн сум, Буянт голын тумба гармын модон гүүрийн засвар	2021.11.12	15.0	2021.11.12	2021.12.12	№12	2021.11.09	100%
18	Алтай 1-р багийн төвөөс хар үзүүр хоорондын замын засвар	2021.06.05	25.7	2021.06.06	2021.06.15	№15	2021.6.25	100%

19	Буянт, доод сайгийн замын засвар	2021.06.02	23.1	2021.06.03	2021.06.15	№14	2021.6.25	100%
НИЙТ ДҮН			274.2					

Эх сурвалж: Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ийн нэгдсэн судалгаа

Зам засварын ажлуудаас “Жол” ХХК 5 төсөл, арга хэмжээг, “Ашекей” ХХК 2 төсөл, арга хэмжээг, “Минамур” ХХК 2 төсөл, арга хэмжээг, “Асгант-кент” ХХК, “Едил Жайых” ХХК, “Сагсай Өргөө” ХХК, “Нур бах” ХХК, Зэвсэгт хүчний 340 дүгээр анги 6 төсөл, арга хэмжээг тус тус шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь зам засварын ажлыг хийж байсан туршлагатай, шаардлага хангасан байна.

Цэнгэл сумын Арал толгой застав, Давааны хаяа уулын замын эхлэлээс Цагаан голын рашаан хүртэлх, Цагаан голын рашаан замын эхлэлээс Даваа хүртэлх замын засварын ажлуудыг Зэвсэгт хүчний 340 дүгээр анги хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, 12.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авсан боловч орон нутагт их хэмжээгээр цас орж, зам хаагдсан гэсэн шалтгаанаар хугацаанд гүйцэтгээгүй байна.

Гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй дээрхи 2 төсөл арга хэмжээг 2022 онд багтаан хэрэгжүүлж дуусгах талаар албан шаардлага өгөгдлөө.

Б.2.2. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд тавигдах техникийн хяналтыг Барилга захиалагчийн алба хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Барилга захиалагчийн албаны замын хяналтын инженер шинээр хэрэгжсэн зам засварын 15 төсөл, арга хэмжээнд техникийн хяналтыг зохих журмаар хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.3. Зам засварын ажлын төсөвт зохиогчийн хяналтын зардал тусгагдаагүйгээс хяналт хэрэгжээгүй байна

Барилга захиалагчийн алба нь зам, гүүрийн засварын ажлын явцад тухай бүр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, зам засварын ажлын үе шат бүрийн фото зургийг авч, гүйцэтгэлийг баталгаажуулан, захиалагчийн нэгдсэн дүгнэлт, гүйцэтгэлийн ажлын тайлан бичиж ажилласан байна.

Мөн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан “Зам, засварын ажлыг байнгын ашиглалтад авах комисс”-ын бүрэлдэхүүнд орж, тухайн онд хэрэгжсэн зам, засварын ажлуудыг ашиглалтад оруулсан байна.

Зураг төсөв зохиогчийн хяналтыг мэргэшсэн төсөвчин нар хэрэгжүүлэх ёстой боловч зам засварын ажлын төсөвт зохиогчийн хяналтын зардлыг тусгагдаагүйн улмаас хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнгээр зураг төсөв зохиогчийн хяналтын зардлыг төсөл арга хэмжээний төсөвт тусгаж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн төсөл арга хэмжээ тус бүрт хяналтын тайлан

бичиж, гүйцэтгэлийн баримтад хавсаргаж ажилласан бөгөөд хяналтаар илэрсэн зөрчил дутагдлуудыг тухай бүрт нь арилгаж ажилласан байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 256.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 17 төсөл арга хэмжээнээс хугацаанд хэрэгжсэн 15 төсөл арга хэмжээнд 227.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гэрээний хугацаанд хэрэгжсэн 15 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн бүрэн олгосон байна.

Хүснэгт №02

	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Ажил эхэлснээс хойш олгосон нийт санхүүжилт	2021 онд олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл		
					Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл, мөнгөн дүн	Тайлант үеийн гүйцэтгэл, мөнгөн дүн	Хувиар
1	Ногооннуур Ямаат хөхсайрын замын засвар	8.4	8.4	5.7	8.4	8.4	100%
2	Улаанхус 1-р баг Хавтгайн / замын засвар	9.8	9.8	9.8	9.8	9.8	100%
3	Улаанхус,4-р багийн / Улиастайн / замын засвар	9.8	9.8	9.8	9.8	9.8	100%
4	Улаанхус 9-р баг, Улаан эрэгт үерийн далан босгох ажил	9.7	9.7	9.7	9.7	9.7	100%
5	Улаанхус , 7-р баг, Билүүд үерийн далан босгох	9.9	9.9	9.9	9.9	9.9	100%
6	Сагсай, Хар нуурын хөвөөний замын засвар	9.8	10.3	10.3	9.8	9.8	105%
7	Ногооннуур, Бөхмөрөн чиглэлийн Ямаат баг, Хөхсайрын замын засвар	9.7	9.7	4.8	9.7	9.7	100%
8	Цэнгэл, Арал толгой застав, давааны хаяа уулын замын эхлэлээс цагаан голын рашаан хүртэлх зам	20.0	6.0	6.0	0	0	0
9	Цэнгэл Арал толгой застав Цагаан голын рашаан замын эхлэлээс Даваа хүртэлх зам	20.0	20.0	6.0	0	0	0
10	Сагсай Даянгийн /хув үе/ гүүрийн засвар	16.0	16.0	16.0	16.0	16.0	100%
11	Баяннуур 1км замын засвар	15.0	15.0	15.0	15.0	15.0	100%
12	Цэнгэл, Ховд гол хавцлын замын засвар	20.0	20.0	20.0	20.0	20.0	100%
13	Өлгий сумын хатуу хучилттай замын нөхөөсний ажил	18.3	18.3	17.7	17.7	17.7	96.7%
14	Булган, Булган голын модон гүүрийн засвар	8.0	8.0	7.9	7.9	7.9	98.7%

15	Цэнгэл, Хоромдогийн модон гүүрийн засвар	20.0	20.0	20.0	20.0	20.0	100%
16	Сагсай, 2-р багийн замын засвар	6.0	6.0	5.9	5.9	5.9	98.3%
17	Дэлүүн сум, Буянт голын тумба гармын модон гүүрийн засвар	15.0	14.8	14.8	14.8	14.8	98.6%
18	Алтай 1-р багийн төвөөс хар үзүүр хоорондын замын засвар	25.7	25.7	25.7	25.7	25.7	100%
19	Буянт, доод сайгийн замын засвар	23.1	23.1	23.1	23.1	23.1	100%
НИЙТ ДҮН		274.2	245.7	238.1	233.2	233.2	

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ийн нэгдсэн судалгаа

Ногооннуур сумын Ямаат Хөхсайрын замын засвар, Бөхмөрөн чиглэлийн Ямаат Хөхсайрын замын засварын ажлыг 2020 онд гэрээний хугацаанд хийж гүйцэтгэж, оны эцэст комисст хүлээлгэн өгсөн боловч гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүйн улмаас үлдэгдэл санхүүжилтийг 2021 онд шилжүүлэн олгосон байна.

Сагсай сумын Хар нуурын хөвөөний замын засварын ажлын санхүүжилтэд 0.5 сая төгрөг илүү олгосныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Өлгий сумын хатуу хучилттай замын нөхөөсний ажлын 0.6 сая төгрөгийн, Булган сумын Булган голын модон гүүрний засварын ажлын 0.1 сая төгрөгийн, Сагсай сумын 2 дугаар багийн замын засварын ажлын 0.1 сая төгрөгийн, Дэлүүн сумын Буянт голын тумба гармын модон гүүрний засварын ажлын 0.2 сая төгрөгийн, нийт 1.0 сая төгрөгийн хяналтын зардлыг дутуу олгосоныг нөхөн олгох, мөн Замын сангийн хөрөнгөнөөс ОНХС-ийн 2 төсөл арга хэмжээний зураг төсвийн үнэд 1.8 сая төгрөгийг шилжүүлсэнийг ОНХС-ийн төсвөөс Замын сангийн дансанд буцаан төлүүлэхээр албан шаардлага өгөв.

Б.3.2. Зам засварын ажлууд нь урсгал засварын шинжтэй ажлууд тул данс бүртгэлд тусгах шаардлагагүй байна

Замын сангийн хөрөнгөөр тайлант онд хэрэгжсэн зам засварын 15 төсөл, арга хэмжээ нь урсгал засварын шинжтэй, бага үнийн дүнтэй, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан давтан засварлах хөрөнгө оруулалт учраас данс бүртгэлд тусгаагүй байна.

Зам засварын 15 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, ашиглалтад орсноор орон нутгийн ард иргэд тухайн замаар зорчиход үүсэж байсан эрсдэл, хүндрэлүүд арилсан байна.

Б.4 Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийгдээгүй байна.

Баян-Өлгий дахь Төрийн аудитын газраас Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад өмнөх онд аудит хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- 1.Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй байна,
- 2.Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.
- 3.Шууд худалдан авалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажиллаагүй байна.
- 4.Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн худалдан авалтын тайланг гаргаагүй байна.
- 5.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Мухамед, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Анар танаа:

1. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Төсвийн тухай хууль, холбогдох журмыг үндэслэж, төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөж батлуулж ажиллах
2. Шууд худалдан авалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажиллах
3. Төсөл арга хэмжээний төсөвт зохиогчийн хяналтын зардлыг тусгаж, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым танаа:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авалтын тайланг гаргаж, тайлагнах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

2022.04.27 № 8-03/44
танай _____ -ны № _____ - т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болох замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд танай байгууллагаас хийсэн аудитын тайлантай танилцав.

Тухайн аудит нь холбогдох хууль, журмын дагуу хийгдсэн гэж үзэж байна. Тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.АНАР

0108220821